



Б Н М А У

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

213

1991 оны 12 сарын 24

№ 361

Улаанбаатар
 хот

УЛСЫН ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР БАЙГУУЛАХ
ТУХАЙ

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас
ТОГТООХ нь:

1. БНМАУ-ын аж ахуйн нэгжийн тухай хуулийг үндэслэн Хот тохижуулах байгууллагуудын одоогийн гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээг хэвээр үлдээж Хот цэцэрлэгжүүлэх трестийг "Цэцэрлэгжилт" компани /УУГ/, Хоёрдогч түүхий эдийн конторыг "Нөөц" компани /УУГ/, Гэрэлтуулэг чимэглэлийн үйлдвэрийг "Гэрэлтуулэг чимэглэл" компани /УУГ/, Хот тохижилтын трестийг "Тохижилт" компани /УУГ/, дүүргүүдийн тохижилт үйлчилгээний трестуудийг "Тохижилт үйлчилгээний I, 2, 3, 4 компани /УУГ/, Зуслангийн төвчоог "Зуслан" компани /УУГ/ болгон тус тус байгуулсугай.

2. Хот тохижилтын бодлого боловсруулан хэрэгжүүлэх, нийтийн эзэмшийн бус дэх аж ахуйн ашиглалт, тохижилт цэцэрлэгжилт, гэрэлтуулэг реклам, хог хаягдлын цэвэрлэгээ тээвэрлэлт, мод цэцэг ургамал уржуулалт, тариалалтын ажилд төхник технологийн хяналт тавих зураг төсвөөр хангах тэдгээрт зарах хөрөнгийг төвлөрүүлэх үр ашигтай зарцуулах материал хангамж, ажиллагсдын мадлэг мэргэжлийг дээшлүүлэх зэрэг асуудлыг хотын АХГЗ-ны нэрийн өмнөөс гүйцэтгэх үргийг Хот тохижуулах газарт хариуцуулсугай.

3. Хот тохижуулах газрын дурмийг I-р хавсралтаар баталж, өөрийн удирдлагад ажиллах ба компаниудын дурмийг баталж өгөхийг Хот тохижуулах газар /н.Отгонсүрэн/-т зөвшөөрсүгэй.

4. Улаанбаатар хотын Хот тохижуулах байгууллагууд /УУГ/-ын дарга нарыг томилон, тэдэнтэй гэрээ байгуулж ажиллахыг Хот тохижуулах газар /н.Отгонсүрэн/-т зөвшөөрсүгэй.

5. Улсын үйлдвэрийн газрын жагсаалт батлах тухай Улаанбаатар хотын АХГ захиргааны 1991 оны 230 дугаар тогтоолын I дүгээр хавсралтанц Хоёрдогч түүхий эдийн конторыг нэмж оруулсугай.

214

2.

6. Хот тохижуулах газрын харьяа зураг төсвийн товчоог татан буулгаж хоршоо болгосугай.

7. Хот тохижуулах газрын орон тоо цалингийн фондыг хянаж батлахыг санхүүгийн газар /н.Гонгор/-т даалгасугай.

8. Энэ тогтоол гарсантай холбогдож Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1987 оны 2-р сарын 29-ны II4, 1990 оны II-р сарын 29-ны 310-р тогтоолын I, 2-р заалт, 1991 оны 86-р тогтоолын 21-р хавсралт, АХ-ын гүйцэтгэх захиргааны 1991 оны 2-р сарын 07-ны 48-р тогтоолын I, 2, 3-р заалтыг тус тус хүчингүй болгосугай.



УВ.ХОТЫН АХЧЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ДАРТА

ХЭРХЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРТА

Л.ЭНЭБИШ

Ц.БОЛДСАИХАН